



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/249


Мөрөн сум

Тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар
сунгах, нэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7, 40 дүгээр зүйлийн 40.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг үндэслэн согтууруулах ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Хөвсгөл геологи" ХК-ийн зоогийн газрын зөвшөөрлийг түр хугацаагаар сунгаж, Мөрөн сумын 7-р багт байрлалтай Ү.Батбаярын эзэмшилийн "Тулгат" хүнсий дэлгүүрийн эзэмшигчийн нэрийг эхнэр Ц.Оюунаар сольж үлдсэн хугацаагаар эзэмшүүлсүгэй.
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандaa (А.Алтанцоож), холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.
- Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.
- Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010144